

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 5 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

### **ЖУРАМ, МАЯГТ, ЗАГВАР БАТЛАХ ТУХАЙ**

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.10, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1, 58.2.5, Захиргааны ерөнхий хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг нэгдүгээр, Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах маягтуудыг хоёрдугаар, аудитын хуулийн этгээдийн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын эцсийн тайланд өгөх аудитын дүгнэлтийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ журмыг Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор /Ц.Наранчимэг/-т даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор /О.Тэнгис/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 5  
дугаар сарын 21-ний өдрийн А/45 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОЖ БАЙГАА НАМ, ЭВСЭЛ, НЭР  
ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН ГАРГАХ,  
ЗАРДЛЫН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХ, ХЯНАХ, ДҮНГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ,  
ТАНИЛЦУУЛАХ ЖУРАМ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**Нэг. Журмын зорилго**

1.1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн санхүүжилтээ хуулиар хүлээн зөвшөөрсөн, бодитой эх үүсвэрээс бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан талаар тайлагнах, түүнд дүгнэлт гаргах, сонгуулийн санхүүжилтийг сонгогч иргэн, олон нийтэд нээлттэй, ил тод байлгах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

**Хоёр. Журмын үйлчлэх хүрээ**

2.1. Энэ журмыг Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн санхүүжилтийн хөрөнгийг хуримтлуулах, сонгуулийн зардал гаргах, сонгуулийн зардлын явцын болон эцсийн тайлан гаргах, сонгуулийн зардлын тайландаа аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулах, Үндэсний аудитын газраас сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулахад дагаж мөрдөнө.

2.2 Энэхүү журам нь тус журмын 17.1-д заасан маягт, 22.7-д заасан дүгнэлтийн загвар бүхий хавсралтаас бүрдэнэ.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ.  
СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ**

**Гурав. Сонгуулийн зардлын данс**

3.1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн /цаашид “хууль” гэх/ 51.1-д зааснаар сонгуульд оролцож байгаа нам, эвсэл болон нэр дэвшигч тус бүр улсын хэмжээнд сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна.

3.2. Эвслийг төлөөлөх байгууллагын шийдвэрээр эвсэлд нэгдсэн нэг нам эвслийг төлөөлж эвслийн сонгуулийн зардлын данс нээлгэх ба эвслийг төлөөлөх байгууллагаас эрх олгогдсон этгээд эвслийн сонгуулийн зардлын данснаас зарлага гаргана.

3.3. Хуулийн 51.2-т зааснаар нам аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбартай бол тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт сонгуулийн зардлын данстай байж болно.

3.4. Нам, эвсэл, нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр гарснаас хойш нам, эвсэл, нэр дэвшигч холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэж сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө Үндэсний аудитын газарт бичгээр мэдэгдэж, бүртгүүлнэ.

**Дөрөв. Сонгуулийн зардлын санхүүжилт**

4.1.Нам, эвслийн сонгуулийн санхүүжилт нь намын өөрийн хөрөнгө, мөнгөн хандиваас бүрдэнэ.

4.2.Нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт нь намын өөрийн хөрөнгө, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, мөнгөн ба мөнгөн бус хандиваас бүрдэнэ.

4.3.Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт нь нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, мөнгөн ба мөнгөн бус хандиваас бүрдэнэ.

#### **Тав. Сонгуулийн зардалд зарцуулах намын өөрийн хөрөнгө**

5.1.Сонгуулийн зардалд зарцуулах намын өөрийн хөрөнгө нь Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу намын өөрийн дансанд хуримтлуулсан мөнгөн хөрөнгө байна.

5.2.Нам энэ журмын 5.1-д заасан хөрөнгийг өөрийн данснаасаа нам, эвслийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлэн зарцуулах ба намын хувьд энэ журмын 3.3-т заасан сонгуулийн зардлын данс нээлгэсэн тохиолдолд уг дансаар дамжуулан зарцуулж болно.

5.3.Нам, эвсэл өөрийн нэр дэвшигчийн сонгуулийн зардалд зориулж олгох намын өөрийн хөрөнгийг нам, эвслийн сонгуулийн зардлын данснаас тухайн нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлэг хийж олгоно.

5.4.Нам, эвсэл сонгуулийн зардалд зарцуулах намын өөрийн хөрөнгийг бусдаас бэлэглэл, зээл хэлбэрээр авч бүрдүүлэхийг хориглоно.

#### **Зургаа. Сонгуулийн зардалд зарцуулах нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө**

6.1.Сонгуулийн зардалд зарцуулах нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан орлогод хамаарах мөнгөн хөрөнгө хамаарна.

6.2.Нэр дэвшигч энэ журмын 6.1-д заасан мөнгөн хөрөнгийг өөрийн данснаасаа сонгуулийн зардлын дансандаа байршуулж зарцуулна.

6.3.Нэр дэвшигч сонгуулийн зардалд зарцуулах өөрийн хөрөнгийг бусдаас бэлэглэл, зээл хэлбэрээр авч бүрдүүлэхийг хориглоно.

#### **Долоо. Сонгуулийн хандив**

7.1.Хуулийн 53.1-д зааснаар сонгуулийн хандив нь мөнгөн ба мөнгөн бус хэлбэртэй байна.

7.2.Хандив нь хандивлагчийн өөрийн хөрөнгө, үйл ажиллагааны орлогын чадамжаас даваагүй, бодитой байна.

7.3.Хандивлагч нэг нам, эвсэл, нэр дэвшигчид хандив өгсөн нь өөр нам, эвсэл, нэр дэвшигчид хандив өгөхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

7.4.Хандивлагч нэр дэвшигчид мөнгөн хандив өгсөн нь тухайн нэр дэвшигчид мөнгөн бус хандив өгөхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

7.5.Хуулийн 56.1-д заасан этгээд хандив өгөхийг хориглох ба нам, эвсэл, нэр дэвшигч шаардсан тохиолдолд хандивлагч нь уг шаардлагыг хангаж байгаа эсэхийг нотлох баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.

#### **Найм. Мөнгөн хандив**

8.1.Хандивлагч этгээдээс эргэж төлөх нөхцөлгүйгээр нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг мөнгөн хандив гэнэ.

8.2.Хуулийн 54.1-д заасны дагуу мөнгөн хандив нь иргэний хувьд таван сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд хорин сая төгрөг хүртэл байна.

8.3.Нам, эвсэл, нэр дэвшигч нь мөнгөн хандивыг зөвхөн сонгуулийн зардлын дансанд хүлээж авна.

8.4.Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын данс хооронд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг хандивт тооцохгүй.

### **Ес. Мөнгөн бус хандив**

9.1.Хандивлагч этгээдээс сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс дуусах хүртэл хугацаанд зөвхөн нэр дэвшигчид үнэ төлбөргүйгээр үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх, үйлчилгээ үзүүлэхийг мөнгөн бус хандив гэнэ.

9.2.Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх мөнгөн бус хандивын гэрээг тухайн эд хөрөнгийн өмчлөгч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдтэй байгуулна.

9.3.Үйлчилгээ үзүүлэх мөнгөн бус хандивыг тухайн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, эсхүл төлөөлөх эрх бүхий этгээдтэй байгуулна.

9.4.Хуулийн 56.5-д заасны дагуу нам өөрийн өмчлөлийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглуулж болох бөгөөд энэ нь хандивт тооцогдохгүй.

### **Арав. Мөнгөн бус хандивын үнэлгээг тодорхойлох**

10.1.Мөнгөн бус хандивын зах зээлийн дундаж үнэлгээг дараах журмаар тодорхойлно:

10.1.1.тухайн эд хөрөнгө ашиглуулсан, эзэмшүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн хандивлагч энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг бол уг үйл ажиллагааны дундаж үнэлгээгээр;

10.1.2.тухайн эд хөрөнгө ашиглуулсан, эзэмшүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн хандивлагч энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагааг эрхэлдэггүй бол тухайн газар нутаг дахь энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн үнийн дундаж үнэлгээгээр.

10.2.Мөнгөн бус хандивын үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгч болох мөнгөн хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

### **Арван нэг. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив**

11.1.Дараах хандивыг хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивт тооцно:

11.1.1.банкны гүйлгээний баримтад хандивлагчийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл бүрэн тусгагдаагүй мөнгөн хандив;

11.1.2.буцах хаяг тодорхойгүй мөнгөн хандив;

11.1.3.хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандив;

11.1.4.хуульд заасан хэмжээнээс хэтэрсэн мөнгөн ба мөнгөн бус хандив.

11.2.Нам, эвсэл, нэр дэвшигчид хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг хүлээн авч, зарцуулах, ашиглахыг хориглоно.

***Тайлбар:** Буцах хаяг тодорхойгүй мөнгөн хандив гэдэгт хандивлагчийн нэр, регистрийн дугаар, банкны дансны дугаар зэрэг мэдээлэл зөрүүтэй байхыг хамруулж ойлгоно.*

**Арван хоёр. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаах, улсын орлогод шилжүүлэх**

12.1.Нам, эвсэл, нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг дараах журмаар буцаан шилжүүлэх буюу улсын орлого болгоно:

12.1.1.энэ журмын 11.1.1, 11.1.3-т заасан мөнгөн хандивыг сонгуулийн зардлын эцсийн тайлан гаргахаас өмнө хандивлагч этгээдэд буцаан шилжүүлэх;

12.1.2.энэ журмын 12.1.1-д заасан хугацаанд буцаан шилжүүлээгүй болон энэ журмын 11.1.2-т заасан мөнгөн хандивыг улсын орлого болгох;

12.1.3.энэ журмын 11.1.4-т заасан хандивыг улсын орлого болгох.

12.2.Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 12.1-д заасны дагуу улсын орлого болгох хандивыг улсын төсвийн орлогын нэгдсэн дансанд тушаана.

### **Арван гурав. Хуулиар зөвшөөрөгдөөгүй мөнгөн хандивыг ашигласанд тооцох**

13.1.Нам, эвсэл, нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй мөнгөн хандивыг сонгуулийн зардлын дансанд хүлээн авснаас хойших сонгуулийн зардлын дансны үлдэгдэл нь уг мөнгөн хандивын хэмжээнээс бага байж болохгүй.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДАЛ**

### **Арван дөрөв. Сонгуулийн зардлын ангилал**

14.1.Сонгуулийн зардлыг нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлалд заасан үзүүлэлтийг харгалзан ангилна.

14.2.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлыг дараах байдлаар ангилж, тайлагнана:

14.2.1.сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, тараах зардал;

14.2.2.нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал;

14.2.3.намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал;

14.2.4.сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал;

14.2.5.сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал:

14.2.5.а.нэр дэвшигчийн ухуулах байрны түрээсийн зардал;

14.2.5.б.нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал;

14.2.5.в.нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал;

14.2.5.г.нам, эвслээс зарцуулах томилолтын зардал;

14.2.5.д.сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал.

14.2.6.сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал;

14.2.7.сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зардал;

14.2.8.өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх зардал;

14.2.9.энэ журмын 14.2.1-14.2.8-д хамаарахгүй бусад зардал.

### **Арван тав. Сонгуулийн зардал гаргах**

15.1.Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын эцсийн тайлан гаргах хүртэл хугацаанд энэ журмын 14.2-т заасан сонгуулийн зардалд зориулан сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргана.

15.2.Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данснаас гаргасан зарлага тус бүрийн зориулалт нь хүчин төгөлдөр анхан шатны баримтаар нотлогдсон байна.

15.3.Нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуулийн зардлын данснаас бэлнээр зарлага гаргахыг хориглоно.

15.4.Дараах зардлын нийт дүн нь сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй:

15.4.1.сонгуулийн зардлын данснаас зарлага болгосон энэ журмын 14.2-т заасан зардлын дүн;

15.4.2.сонгуулийн зардалтай холбоотой өр төлбөрийн дүн;

15.4.3.мөнгөн бус хандивын хэмжээ /энэ заалт нь зөвхөн нэр дэвшигчид хамаарна/.

15.5.Энэ журмын 15.4-т заасан зардлын дүн нь сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд илүү гарсан хэсэгтэй тэнцэх хэмжээний мөнгөн төлбөрийг нам, эвсэл, нэр дэвшигч улсын орлого болгоно.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН**

#### **Арван зургаа. Сонгуулийн зардлын тайлан**

16.1.Сонгуулийн зардлын тайланг мөнгөн ба мөнгөн бус гэж ангилна.

16.2.Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын явцын болон эцсийн тайлан гаргана.

16.3.Сонгуулийн зардлын тайланд нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуульд зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр ба зарлагын мэдээллийг бүрэн тусгана.

#### **Арван долоо. Сонгуулийн зардлын явцын тайлан гаргах**

17.1.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн өмнө Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах Маягт (1-9)-ын дагуу гаргаж, Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

17.2.Нийслэлээс бусад тойрогт нэр дэвшигч энэ журмын 18.1-д заасан хугацаанд сонгуулийн зардлын явцын тайлангийн эх хувийг ирүүлэх боломжгүй тохиолдолд цахим хуулбарыг Үндэсний аудитын газрын цахим шууданд илгээж, эх хувийг санал авах өдрөөс 1 хоногийн өмнө Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

17.3.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын явцын тайланд данс нээлгэсэн өдрөөс сонгуулийн зардлын явцын тайлан гаргах хүртэлх хугацааны сонгуулийн зардлын дансны хуулгыг хавсаргана.

#### **Арван найм. Сонгуулийн зардлын явцын тайланг нийтэд мэдээлэх**

18.1.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын явцын тайланг санал авах өдрөөс хойш 3 хоногийн өмнө дараах хэлбэрээр нийтэд мэдээлнэ:

18.1.1.хуулийн 47.1.1, 47.1.2-т заасан цахим хуудаст байршуулах;

18.1.2.өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд байршуулах;

18.1.3.мэдээллийн сайт болон бусад олон нийтийн сүлжээнд байршуулах.

18.2.Үндэсний аудитын газар нам, эвсэл болон нэр дэвшигчээс ирүүлсэн сонгуулийн зардлын явцын тайланг хүлээн авмагц өөрийн цахим хуудаст байршуулж, хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын явцын тайланг ирүүлээгүй нам, эсвэл, нэр дэвшигчийг нийтэд мэдээлнэ.

### **Арван ес. Сонгуулийн зардлын эцсийн тайлан гаргах**

19.1.Хуулийн 57.3-т заасны дагуу нам, эвсэл санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын эцсийн тайланг энэ журмын 17 дугаар зүйлд заасан тайланг өссөн дүнгээр эцэслэн гаргаж, аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

19.2.Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 19.1-д заасны дагуу Үндэсний аудитын газарт ирүүлэх сонгуулийн зардлын эцсийн тайландаа дараах баримт бичгүүдийг хавсаргасан байна:

19.2.1.сонгуулийн зардлын дансны хуулга;

19.2.2.сонгуулийн зардлын тайланд тусгасан орлого, зарлагыг нотлох анхан шатны баримт;

19.2.3.байгуулсан гэрээ, хэлцлийн хуулбар;

19.2.4.нэр дэвшигч мөнгөн бус хандив авсан бол хандивын гэрээний хуулбар, хандивын гэрээний үнэлгээг тодорхойлсон нотлох баримт.

### **Хорь. Сонгуулийн зардлын эцсийн тайланг нийтэд мэдээлэх**

20.1.Нам, эвсэл, нэр дэвшигч аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан сонгуулийн зардлын эцсийн тайланг энэ журмын 18.1-д заасан хэлбэрээр нийтэд мэдээлнэ.

20.2.Үндэсний аудитын газар энэ журмын 20.1-д заасны дагуу ирүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын эцсийн тайланг цахим хуудастаа байршуулж, хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын эцсийн тайланг ирүүлээгүй нам, эсвэл, нэр дэвшигчийг нийтэд мэдээлнэ.

### **Хорин нэг. Үндэсний аудитын газар сонгуулийн зардлын эцсийн тайланг хянах, дүнг мэдээлэх**

21.1.Үндэсний аудитын газар энэ журмын 19.1-д заасны дагуу ирүүлсэн сонгуулийн зардлын эцсийн тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ.

21.2.Үндэсний аудитын газар сонгуулийн зардлын эцсийн тайланг хянахдаа хуулийн 58.2.2-58.2.4-т заасан болон Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

21.3.Үндэсний аудитын газар энэ журмын 21.2-т заасан бүрэн эрхийн дагуу мэдээлэл, баримт шаардсан тохиолдолд холбогдох нам, эвсэл, нэр дэвшигч, бусад иргэн, хуулийн этгээд мэдээлэл, баримтыг тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

21.4.Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 12.1, 15.5-д заасан мөнгөн хөрөнгийг улсын орлого болгоогүй тохиолдолд уг зөрчлийг Үндэсний аудитын газар холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ.

**Хорин хоёр. Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын эцсийн тайланд дүгнэлт гаргах**

22.1.Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийх аудитын хуулийн этгээд нь Аудитын тухай хуульд заасны дагуу ажил төрөл, хувийн харилцаа холбоо, ашиг сонирхлын хувьд нам, эвсэл, нэр дэвшигчээс хараат бус байх шаардлагыг хангасан байна.

22.2.Сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийхээр нам, эвсэл, нэр дэвшигчтэй гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд нь энэ журмын 22.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй талаарх мэдэгдэл, тайлбараа гэрээ байгуулснаас хойш 2 хоногийн дотор Үндэсний аудитын газарт мэдэгдэнэ.

22.3.Аудитын хуулийн этгээд энэ журмын 22.2-т заасны дагуу гэрээ байгуулснаас хойш аливаа шалтгаанаар сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийгээгүй, аудит хийхээс татгалзсан тохиолдолд энэ тухай мэдэгдэл, тайлбараа 2 хоногийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

22.4.Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын эцсийн тайланд хийх аудитыг тухайн нам, эвсэл, нэр дэвшигчээс энэ журмын 17.1-д заасан маягтын дагуу гаргасан тайлан, энэ журмын 19.2-т заасан баримт бичиг болон анхан шатны баримтад үндэслэн хийнэ.

22.5.Холбогдох нам, эвсэл, нэр дэвшигч нь аудитын хуулийн этгээдээс шаардсан баримт бичиг, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж өгөх, эсхүл гуравдагч этгээдээс гаргуулж өгөх, аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах үүрэгтэй.

22.6.Аудитын хуулийн этгээд дараах асуудлуудын хүрээнд сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийж дүгнэлт гаргана:

22.6.1.сонгуулийн зардлын тайланг батлагдсан маягтын дагуу иж бүрэн гаргаж, баталгаажуулсан эсэх;

22.6.2.сонгуулийн зардалд зарцуулсан намын болон нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн эх үүсвэр нь тодорхой, бодитой эсэх;

22.6.3.хүлээн авсан мөнгөн хандив нь хуулиар зөвшөөрөгдсөн, эх үүсвэр нь тодорхой, бодитой эсэх;

22.6.4.хүлээн авсан мөнгөн бус хандивын үнэлгээг бодитой тодорхойлсон эсэх;

22.6.5.сонгуулийн зардлын тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв тусгагдсан эсэх;

22.6.6.сонгуулийн зардлын зарцуулалт зориулалтын дагуу бодитой хийгдсэн бөгөөд анхан шатны баримтыг үндэслэн сонгуулийн зардлын тайланд үнэн зөв тусгагдсан эсэх.

22.7.Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийхдээ Аудитын олон улсын стандартыг баримталж, Аудитын олон улсын стандарт 800 “Тусгай зорилго бүхий үзэл баримтлалд нийцүүлэн бэлтгэсэн санхүүгийн тайлангийн аудит”-г удирдлага болгон Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан загварын дагуу дүгнэлт гаргана.



22.8.Аудитын хуулийн этгээд аудитын явц үр дүн болон энэ журмын 22.7-д заасан дүгнэлтэд дэмжлэг болгох зорилгоор дараах бүтэц, агуулга бүхий аудитын дэлгэрэнгүй тайлан, дүгнэлтийн хамт Үндэсний аудитын газарт ирүүлнэ:

22.8.1.аудит хийсэн үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага;

22.8.2.аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт;

22.8.3.тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал;

22.8.4.материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар;

22.8.5.аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн;

22.8.6.илрүүлсэн зүйлсийн нэгтгэл, тайлбар;

22.8.7.санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.

### **ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗААЛТ**

**Хорин гурав. Сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад иргэд, олон нийтийн байгууллагын оролцоо**

23.1.Сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад иргэд, олон нийтийн байгууллага дараах оролцоотой байна:

23.1.1.сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад оролцох, хөндлөнгийн ажиглалт хийх;

23.1.2.сонгуулийн зардалтай холбоотой гарсан зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдлийн талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад гомдол, мэдээлэл гаргах;

23.1.3.нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг үнэн зөв, бодитой гаргасан эсэх талаар дүн шинжилгээ хийх, санал, зөвлөмж гаргах.

**Хорин дөрөв. Хариуцлага**

24.1.Үндэсний аудитын газар нь сонгуулийн зардлын тайлангийн аудитын дүгнэлтийг үнэн зөв, бодитой гаргаагүй, илт худал дүгнэлт гаргасан, эсхүл хуульд заасныг зөрчиж аудит хийсэн аудитын хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

24.2.Үндэсний аудитын газар сонгуулийн зардлын тайлантай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйл баримт илэрсэн тохиолдолд энэ тухай мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шалгуулна.

24.3.Үндэсний аудитын газрын хийсэн аудитын дүгнэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар зохицуулна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 5  
дугаар сарын 21-ний өдрийн А/45 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

**НАМЫН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ**

*Маягт-1-1*  
*... оны ...-р сарын ...-ны өдөр*

Тайлан ирүүлсэн огноо:

Тайлангийн төрөл:

*Сонгуулийн өдрөөс 3 хоногийн өмнөх явцын тайлан*  
*Сонгуулийн дараах эцсийн тайлан*

**НЭГ. НАМЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Намын  
нэр: \_\_\_\_\_

Регистрийн  
дугаар: \_\_\_\_\_

Нэр дэвшүүлсэн хүний  
тоо: \_\_\_\_\_

**ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны  
нэр: \_\_\_\_\_

Дансны  
дугаар: \_\_\_\_\_

Гүйлгээ хийж эхэлсэн огноо:

*сарын ...-ны өдөр*

*... ОНЫ ...-р*

Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо:

*сарын ...-ны өдөр*

*... ОНЫ ...-р*

Эхний

үлдэгдэл: \_\_\_\_\_

Аймаг, нийслэл, сум, дүүрэгт зардлын данстай  
эсэх:  Тийм  Үгүй

Хэрэв тийм бол:

Орон нутгийн салбарын нийт дансны

тоо: \_\_\_\_\_

*Нийт*

*орлого:*

\_\_\_\_\_ *төгрөг*

\_\_\_\_\_ -

*Нийт*

*зарлага:*

\_\_\_\_\_ *төгрөг*

\_\_\_\_\_

<b>ГУРАВ. НАМЫН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН</b>		
<b>Үзүүлэлт</b>	<b>Дүн /төгрөгөөр/</b>	<b>Тоо</b>
<b>1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>		
1.1 Намын өөрийн хөрөнгө		
1.2 Хуулийн этгээдийн хандив		
1.3 Иргэний хандив		
<b>2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>		
2.1 Сонгуулийн зардал		
2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		
2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал		
2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		
2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		
2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		
2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах		
2.1.7 цахим орчин ашиглах зардал		
2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал		
2.2 Бусад зардлын дүн		
<b>3. ҮЛДЭГДЭЛ</b>		
<b>4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ</b>		
<b>5. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР</b>		
<b>6. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ</b>		
6.1 буцаасан хандив		

6.2 улсын орлого болгосон хандив		
(Анхаарах: Дээрх бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна)		

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН: / Овог нэр /  
/ Албан тушаал /

ТАЙЛАН ХЯНАСАН: / Овог нэр /  
/ Албан тушаал /

### ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Маягт-1-2

Тайлан ирүүлсэн огноо:

... оны ...-р сарын ...-ны өдөр

Тайлангийн төрөл:

Сонгуулийн өдрөөс 3 хоногийн өмнөх явцын тайлан  
Сонгуулийн дараа эцсийн тайлан

<b>НЭГ. ЭВСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ</b>	
Эвслийн нэр:	_____
Эвсэлд нэгдсэн намын тоо:	_____
Нэр дэвшүүлсэн хүний тоо:	_____
<b>ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	
Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр:	_____
Дансны дугаар:	_____
Гүйлгээ хийж эхэлсэн огноо:	... оны ...-р сарын ...-ны өдөр
Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо:	... оны ...-р сарын ...-ны өдөр
Эхний үлдэгдэл:	_____
<b>ГУРАВ. ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН</b>	

Үзүүлэлт	Хэмжээ /төгрөгөөр/	Тоо
<b>1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>		
1.1 Намуудаас оруулсан өөрийн хөрөнгө		
Нам 1 /нэр/		
Нам 2 /нэр/		
Нам 3 /нэр/		
...		
1.2 Хуулийн этгээдийн хандив		
1.3 Иргэний хандив		
<b>2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>		
2.1 Сонгуулийн зардал		
2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		
2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал		
2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		
2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		
2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		
2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах		
2.1.7 цахим орчин ашиглах зардал		
2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал		
2.2 Бусад зардлын дүн		
<b>3. ҮЛДЭГДЭЛ</b>		
<b>4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ</b>		



Гүйлгээ хийж эхэлсэн огноо: ...  
 оны ...-р сарын ...-ны өдөр  
 Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо: ...  
 оны ...-р сарын ...-ны өдөр  
 Эхний  
 үлдэгдэл: \_\_\_\_\_

**ГУРАВ. НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

Үзүүлэлт	Хэмжээ /төгрөгөөр/	Тоо
<b>1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>		
1.1 Нам/эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө		
1.2 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө		
1.3 Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив		
1.3.1 Мөнгөн хандив		
1.3.2 Мөнгөн бус хандив		
1.4 Иргэний өгсөн нийт хандив		
1.4.1 Мөнгөн хандив		
1.4.1 Мөнгөн хандив		
<b>2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>		
2.1 Сонгуулийн зардал		
2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		
2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал		
2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		
2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		
2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		

	2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах		
	2.1.7 цахим орчин ашиглах зардал		
	2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал		
	2.2 Бусад зардлын дүн		
<b>3. ҮЛДЭГДЭЛ</b>			
<b>4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ</b>			
<b>5. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР</b>			
<b>6. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ</b>			
	6.1 буцаасан дүн		
	6.2 улсын орлого болгосон		
(Анхаарах: Дээрх бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна)			

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/Овог нэр/  
/Албан тушаал/

ТАЙЛАН ХЯНАСАН:

/Овог нэр/  
/Албан тушаал/

**НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН**

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_

/Маягт-2/

№	Дансны дугаар, банкны нэр	Мөнгөн дүн	Огноо	Эх үүсвэр
1.				
2.				
3.				
<b>Нийт дүн</b>				



**Заавар:** Мөнгөн дүн, огноо, эх үүсвэрийг гүйлгээ тус бүрээр нэг бүрчлэн бичнэ. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын дансандаа төвлөрүүлсэн нам, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийг ямар эх үүсвэрээс бүрдүүлсэн талаараа үнэн зөв, тодорхой бичнэ.

Тайлан бэлтгэсэн: \_\_\_\_\_ /овог, нэр/  
 \_\_\_\_\_ /албан тушаал/

Тайлан хянасан: \_\_\_\_\_ /овог, нэр/  
 \_\_\_\_\_ /албан тушаал /

**МӨНГӨН ХАНДИВЫН ТАЙЛАН**

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_

*/Маягт-3/*

№	Хандивлагч		Хандивын хэмжээ /төгрөг/	Хандивын эх үүсвэр*	Хандивласан огноо
	Нэр	Регистрийн дугаар			
1.	Иргэн				
2.					
3.					
		Дүн			
1.	Хуулийн этгээд				
2.					
3.					
		Дүн			
	Нийт дүн				

\*Хандивын эх үүсвэрийн мэдээллийг зөвхөн банкны гүйлгээний баримтад тусгагдсан байдлаар бичнэ.

Тайлан бэлтгэсэн: /овог, нэр/

/албан тушаал/

Тайлан хянасан: /овог, нэр/

/албан тушаал /

### МӨНГӨН БУС ХАНДИВЫН ТАЙЛАН

Нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_

/Маягт-4/

№	Хандивлагч		Хандивлагчийн хаяг	эд хөрөнгө болон авсан үйлчилгээний мэдээлэл, хандивын зориулалт*	Гэрээний дугаар	Хандивын хэмжээ /хандивын гэрээнд зааснаар/	огноо
	Нэр	Регистрийн дугаар					
1.	Иргэн						
2.							
3.							
	Дүн						
1.	Хуулийн этгээд						
2.							
3.							
	Дүн						
	Нийт дүн						

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/ /албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/ /албан тушаал /

\*Эзэмшүүлсэн, ашиглуулсан эд хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгө тохиолдолд улсын бүртгэлийн дугаар, тээврийн хэрэгсэл тохиолдолд улсын дугаар, бусад хөдлөх эд хөрөнгө тохиолдолд хөрөнгийн марк, нэр, эд хөрөнгө эзэмшсэн, ашигласан, авсан үйлчилгээний зориулалтыг тодорхой бичнэ.

**Мөнгөн бус хандивын хэмжээг тодорхойлох жишээ:**

- Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэггүй этгээд дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр ашиглуулжээ. Энэ тохиолдолд нэр дэвшигч тухайн орон нутаг дахь ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг этгээдээс уг тоног төхөөрөмжийг ашиглахад ямар хөлс төлөхийг судлах замаар мөнгөн бус хандивын үнэлгээг тодорхойлно.
- Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэг этгээд нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр ашиглуулсан тохиолдолд уг мөнгөн бус хандивын хэмжээг тухайн этгээд энэ төрлийн үйлчилгээ үзүүлээд авдаг хөлсний дундаж үнэлгээгээр тодорхойлно.

**ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫН ТАЙЛАН**

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_

*/Маягт-5/*

№	Хандивлагч иргэн, хуулийн этгээдийн нэр /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивлагчийн регистрийн дугаар /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивын хэмжээ	Хандивын хэлбэр	Огноо	Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив гэж үзсэн тухай тайлбар
1.						
2.						
3.						
Нийт дүн						

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/  
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/

/албан тушаал /

**ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫГ БУЦААСАН БУЮУ УЛСЫН ОРЛОГО  
БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН**

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_

*/Маягт-6/*

№	Хандивлагч иргэн, хуулийн этгээдийн нэр /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивлагчийн регистрийн дугаар /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивын хэмжээ	Шилжүүлгийн мэдээлэл		Буцаасан, улсын орлого болгосон тухай тайлбар	Огноо
				Буцаасан	Улсын орлого болгосон		
1.							
2.							
3.							
Нийт дүн							

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/

/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/

/албан тушаал /

**СОНГУУЛИЙН ЗАРДАЛТАЙ ХОЛБООТОЙ ӨГЛӨГИЙН ТАЙЛАН**

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_

*/Маягт-7/*

№	Зардлын зориулалтын тайлбар	Нэхэмжлэгч этгээдийн		Төлөх дүн	Төлөөгүй байгаа шалтгаан, цаашид авах арга хэмжээ
		Нэр	Регистрийн дугаар		
1.					
2.					
3.					
Нийт дүн					

Тайлан бэлтгэсэн: \_\_\_\_\_ /овог, нэр/

\_\_\_\_\_ /албан тушаал/

Тайлан хянасан: \_\_\_\_\_ /овог, нэр/

\_\_\_\_\_ /албан тушаал /

**СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ ТУС БҮРЭЭР ХИЙСЭН ОРЛОГЫН  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_

/Маягт-8/

Тайлан гаргасан: Хянаж баталгаажуулсан:

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр, гарын үсэг, тамга Аудитын хуулийн этгээдийн нэр, гарын үсэг, тамга

**СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ ТУС БҮРЭЭР ХИЙСЭН ЗАРЛАГЫН  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_

/Маягт-9/

Тайлан гаргасан: Хянаж баталгаажуулсан:

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр, гарын үсэг, тамга Аудитын хуулийн этгээдийн нэр, гарын үсэг, тамга

*Сонгуулийн өдрөөс 3 хоногийн өмнөх явцын тайлан*

*... оны ...-р сарын ...-ны өдөр*

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн  
А/45 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**(нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр)-д**

Хараат бус аудитын дүгнэлт

Улсын Их Хурлын ..... оны ээлжит сонгуульд оролцогч *(нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр)*-ын сонгуулийн зардлын тайланд аудит хийж дүгнэлт гаргалаа.

**Дүгнэлт**

Бидний дүгнэлтээр *(Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр)*-ын Улсын Их Хурлын ..... оны ээлжит сонгуулийн зардлын тайлан, түүний тодруулга мэдээллүүд бүхий л материаллаг асуудлаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, тогтоомжийн дагуу үнэн зөв, иж бүрэн *(илэрхийлэгдсэн / илэрхийлэгдээгүй)* байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитыг Төрийн аудитын тухай хууль, Аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 болон энэ хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.5-д заасан журмын дагуу Аудитын олон улсын стандарт, Монгол Улсын “Төрийн аудит MNS 6817 – (1-8): 2020” стандартыг тус тус удирдлага болгон гүйцэтгэлээ. Эдгээр стандарт шаардлагын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл хэсэгт харуулав.

Аудитаар сонгуулийн зардлын тайлан дах дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, чухал тооцооллыг үнэлж цэгнэн, зардлын тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудитаар сонгуулийн зардлын тайлан үнэн зөв, иж бүрэн, материаллаг *(алдаагүй / алдаатай)* илэрхийлэгдсэн гэж дүгнэв. Бидний хийсэн аудит дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэж үзэж байна.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Улсын Их Хурлын ..... оны ээлжит сонгуульд оролцогч нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасан Сонгуулийн зардлын тайланг энэ хууль болон холбогдох журмын дагуу бэлтгэж, хараат бус аудитын дүгнэлт гаргуулах үүрэгтэй.

Сонгуулийн зардлын тайлан, бусад тодруулга мэдээлэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн баталсан холбогдох журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт гаргах нь аудитын байгууллагын үүрэг юм.

Хараат бус аудитын дүгнэлтэд /..... хуудас/ материал хавсаргав.

Хувийг: Үндэсний аудитын газарт

Гарын үсэг

Тамга тэмдэг